



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 26 өдөр


Дугаар 4/606

Улаанбаатар хот

Түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үед эсрэг төрөгч (антиген) илрүүлэх хурдавчилсан оношлуураар шинжилгээ хийх түр заавар”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын вирусын нуклейн хүчилд суурилсан бодит хугацааны-урвуу транскриптазат-полимеразын гинжин урвал (БХ-УТ-ПГУ)-ын шинжилгээ хийх түр заавар”-ыг хоёрдугаар, “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үед эсрэг бие илрүүлэх хурдавчилсан шинжилгээ хийх түр заавар”-ыг гуравдугаар, “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үед эсрэг бие илрүүлэх фермент холбоот урвал (ФХУ), электрохемолюминесценцийн шинжилгээ (ХЛИА) хийх түр заавар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- Энэхүү түр зааврыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
- Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-т, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д, Эрүүл мэндийн яамны дэргэдэх лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл /Б.Дармаа/-д тус тус үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.
- Энэхүү тушаал гарсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 сарын 28-ны өдрийн А/267 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын Хүснэгт 1-ийг хүчингүй болгосугай.



141202497

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ҮЕД  
ЭСРЭГ ТӨРӨГЧ (АНТИГЕН) ИЛРҮҮЛЭХ ХУРДАВЧИЛСАН ОНОШЛУУРААР  
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТҮР ЗААВАР

**НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

1.1. Эсрэг төрөгч илрүүлэх хурдавчилсан оношлуур нь хүний амьсгалын дээд замд SARS-CoV-2 вирусын өвөрмөц уургийг чанарын аргаар илрүүлэх иммунохроматографийн арга юм. Шинж тэмдэг илрэхийн өмнөх үед (1-3 хоногийн өмнө), шинж тэмдэг илрэх эхний үед (өвчиний эхний 5-7 хоногт) вирусын ачаалал өндөр байх үед ( $Ct$  утга  $\leq 25$  эсвэл  $>10^6$  копи/мл) хэрэглэх нь илүү үр дүнтэй. Харин шинж тэмдэг илэрснээс хойш 5-7 хоногоос дээш хугацаанд вирусын хэмжээ багасах бөгөөд эсрэг төрөгч илрүүлэх хурдавчилсан оношлуураар хуурамч сөрөг үр дүн гарахаад боломжгүй, шинжилгээний хариу гарах хугацаа нь эмнэлзүйн шийдвэр гаргахад хулээгдэхээр байгаа үед мэдрэг чанар  $>80\%$ , өвөрмөц чанар  $\geq 97\%$  гэсэн наад захын шалгуурыг хангасан SARS-CoV-2-ийн антиген (эсрэг төрөгч) илрүүлэх хурдавчилсан оношлуурыг хэрэглэх боломжтой.

1.2. Эсрэг төрөгч илрүүлэх хурдавчилсан оношлуурын шинжилгээний үр дүн нь дангаараа оношийн үндэслэл болохгүй, БХ-УТ-ПГУ шинжилгээгээр оношийг баталгаажуулна.

1.3. Үйлдвэрлэгчийн зааврын дагуу сургагдсан ажилтан шинжилгээг гүйцэтгэнэ.

**ХОЁР. ЭСРЭГ ТӨРӨГЧ ИЛРҮҮЛЭХ ХУРДАВЧИЛСАН ОНОШЛУУРЫН ШИНЖИЛГЭЭГ ХИЙХ ТОХИОЛДОЛ**

2.1. БХ-УТ-ПГУ-ын шинжилгээг даруй хийх боломжгүй, алслагдсан орон нутгийн хүн ам, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч, дотуур байр гэх мэт бүлэг хүмүүсийн дунд коронавируст халдварт (КОВИД-19)-ын дэгдэлтийг сэжиглэж буй үед хариу арга хэмжээг эрт эхлүүлэх зорилгоор хэрэглэнэ. Шинжилгээ зэрэг гарвал тухайн сорьцыг нэн даруй БХ-УТ-ПГУ-ын баталгаажуулах шинжилгээнд илгээнэ.

2.2. БХ-УТ-ПГУ-аар батлагдсан коронавируст халдварт (КОВИД-19)-ын дэгдэлт болсон газар нутаг, сургууль, асрамжийн газар, хорих анги, цэргийн анги, сэтгэцийн эмнэлэг, ажлын байр, дотуур байр гэх мэт орчинд дэгдэлтийг илрүүлэхэд дэмжлэг болох зорилгоор эрсдэлтэй хүмүүст хийж зэрэг тохиолдлыг хурдан тусгаарлаж хариу арга хэмжээг зохион байгуулан эргэлзээтэй сорьцыг нэн даруй БХ-УТ-ПГУ баталгаажуулах шинжилгээнд илгээнэ.

2.3. Зорилтот бүлгийн хүнд, тухайлбал эрүүл мэндийн ажилтнуудын дунд өвчлөлийн чиг хандлагыг хянах, халдвартын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг үр дүнтэй чиглүүлэх зорилгоор, тодорхой бүс нутагт халдвартын тархалт өргөн тархсан үед хурдавчилсан шинжилгээ хийнэ. Эерэг гарсан тохиолдлын сорьцыг нэн даруй БХ-УТ-ПГУ баталгаажуулах шинжилгээнд илгээнэ.

2.4. Хүн амын дунд халдварт өргөн тархсан үед эрүүл мэндийн байгууллага, коронавируст халдварт (КОВИД-19)-ын оношилгооны төв, сургууль, асрамжийн газар,

хорих анги, голомтод ажиллаж буй болон эрүүл мэндийн ажилтанд халдварт илрүүлэх тусгаарлах, хавьтлыг мөшгөх зорилгоор хэрэглэнэ.

2.5. Эмнэлзүйн шинж илэрсэн хүнд халдвартыг илрүүлэх зорилгоор БХ-УТ-ПГУ шинжилгээ хийх боломжгүй сум, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг эрүүл мэндийн анхан шатны байгууллагад ашиглаж болно.

## **ГУРАВ. ЭСРЭГ ТӨРӨГЧ ИЛРҮҮЛЭХ ХУРДАВЧИЛСАН ОНОШЛУУРЫН ШИНЖИЛГЭЭГ ХИЙХГҮЙ ТОХИОЛДОЛ**

3.1. Батлагдсан тохиолдолтой хавьтал болоогүй, эмнэлзүйн шинж тэмдэггүй хүнд;

3.2. Биоаюулгүйн байдал, халдвартын сэргийлэлт, хяналт хангалтгүй нөхцөлд;

3.3. Шинжилгээний үр дүнд суурилан өвчтөний эмчилгээний тактикийг өөрчлөхгүй үед;

3.4. Тархалт багатай бүс нутагт цусны донор, хагалгаанд орох өвчтөнд;

3.5. Тухайн бүс нутагт батлагдсан тохиолдол гараагүй бол харуулдан тандалтын зорилгоор

## **ДӨРӨВ. ХОРИГЛОХ БОЛОН АНХААРУУЛАХ ЗҮЙЛ**

### **4.1 Хориглох зүйл**

4.1.1. Оношлуурын цомгийг дахин давтан хэрэглэх;

4.1.2. Бүрэн бүтэн байдал алдагдсан болон гэмтсэн;

4.1.3. Оношлуур дахь ялгах буферийг лот хооронд сольж хэрэглэх;

4.1.4. Шинжилгээ хийх үед идэх, уух, тамхи татах;

4.1.5. Оношлуурыг онгойлгоход чийг татагчийн өнгө өөрчлөгдөж, шараас ногоон өнгөтэй болсон бол оношлуурыг хэрэглэхгүй

### **4.2. Анхааруулах зүйл**

4.2.1. Оношлуурыг хэрэглэх үед хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн, зөв өмсөнө.

4.2.2. Шаардлагатай халдвартгүйжүүлэгч бодисыг хэрэглэнэ.

4.2.3. Бүх сорьцыг халдвартай материал гэж үзэж харьцана.

4.2.4. Шинжилгээ хийх үйл явцад микробиологийн лабораторийн халдварт хамгааллын журмыг мөрдөж ажиллана.

4.2.5. Бүх шинжлэгдэхүүн, хэрэглэсэн материалыг биологийн аюултай хог, хаягдлын журмыг баримтлан устгана.

4.2.6. Шинжилгээ хийхэд, анхааруулга, хариуны дүгнэлт хийхдээ үйлдвэрлэгчийн зааврыг хатуу мөрдөнө.

4.2.7. Шинжилгээний ажилбар болон хариуг дүгнэхэд гаргасан алдаа нь шинжилгээний үр дүнд нөлөөлж болзошгүй.

### **4.3. Хуурамч сөрөг гарч болох тохиолдол**

4.3.1. Оношлуурын хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдах

4.3.2. Сорьц буруу авах

4.3.3. Ялгах буферт сорьцыг дутуу холих

### **4.4. Хариуг үнэлэх**

4.4.1. Шинжилгээний хариу нь бусад эмнэлзүйн мэдээлэлтэй хамт үнэлэгдэнэ.

4.4.2. Эрэг болон сөрөг хариу нь бусад эмгэг төрүүлэгчтэй хам халдвартыг үгүйсгэхгүй.

4.4.3. Насанд хүрэгчид болон хүүхдэд оношлуурын мэдрэг чанарын ялгаатай байдал шинжилгээний хариунд нөлөөлж болно.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ВИРУСЫН НУКЛЕЙН  
ХҮЧИЛД СУУРИЛСАН БОДИТ ХУГАЦААНЫ-УРВУУ  
ТРАНСКРИПТАЗАТ-ПОЛИМЕРАЗЫН ГИНЖИН УРВАЛ (БХ-УТ-ПГУ)-ЫН  
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТҮР ЗААВАР

**НЭГ. СОРЬЦ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ**

1.1. SARS-CoV-2 вирусыг илрүүлэх лабораторийн оношилгооны нуклейн хүчилд суурилсан (БХ-УТ-ПГУ) шинжилгээнд сорьц авахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан зааврыг мөрдөнө.

1.2. Амьсгалын замаас сорьц авах аргачилсан заавар бүхий видео хичээлийг вэбсайт <https://www.youtube/hOzJ9EzZTe8> холбоосоор үзэж мэргэжилтэн бэлтгэнэ.

1.3. БХ-УТ-ПГУ-ын шинжилгээг олныг хамруулан хийх тохиолдолд хамар-залгиураас авсан сорьцыг вирус зөөвөрлөх орчинд тээвэрлэнэ.

1.4. БХ-УТ-ПГУ-ын шинжилгээний сорьц авсан бамбарыг хөдөө орон нутгаас хуурайгаар нь хуруу шилэнд хийж сайтар бөглөж тээвэрлэнэ.

1.5. Дүүрэг, эмнэлэг, эрүүл мэндийн төвөөс БХ-УТ-ПГУ-ын шинжилгээний сорьцын бамбарыг 1.5 мл-ээр савласан 0.9%-ийн NaCl ариун уусмал бүхий хуруу шилэнд хийж сорьцыг тасалгааны хэмд тээвэрлэн 24-48 цагийн дотор ХӨСҮТ, ЗӨСҮТ эсвэл орон нутгийн харьяа лабораторид хүргүүлнэ.

1.6. БХ-УТ-ПГУ-ын шинжилгээний сорьц авахад модон иштэй, хөвөн бамбар хэрэглэхгүй.

1.7. Зориулалтын уян, нарийн иштэй, үстэй бамбар эсвэл полиэстер, дакрон бамбар хэрэглэнэ.

1.8. Сорьц тээвэрлэхэд Эрүүл мэндийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны А/419/A/165 дугаар тушаалыг мөрдөнө.

**ХОЁР. БХ-УТ-ПГУ ХЭРЭГЛЭХ ТОХИОЛДОЛ**

2.1. КОВИД-19 халдвартыг илрүүлэх, баталгаажуулах, тандах, хянах, эмчилгээний хяналт хийх зэрэг бүх тохиолдолд БХ-УТ-ПГУ-ын шинжилгээг хийнэ

2.2. Өвчтөний эмнэлзүй, тархвар судлалын өгүүлээмжийг харгалзан хавьтал болсноос хойш 3-5 хоног, эмнэлзүйн шинж тэмдэг эхэлснээс хойш эхний 7 хоногт хамар залгиурын арчдас, ам залгиурын арчдас, түүнээс хойш хугацаанд амьсгалын доод замын сорьц болох цэр, бронх альвеолын угаадас, өтгөн, эмнэлзүйн хүнд өвчтөнд цус гэх мэт сорьцонд уг шинжилгээг хийнэ.

**ГУРАВ. БХ-УТ-ПГУ -ЫН ШИНЖИЛГЭЭНД СОРЬЦЫГ БАГЦЛАХ ТАЛААР**

БХ-УТ-ПГУ -ын шинжилгээнд сорьцыг багцалж хийж **БОЛОХГҮЙ** тохиолдлууд:

- 3.1. КОВИД-19 халдвартын батлагдсан тохиолдлын ойрын хавьтал;
- 3.2. Батлагдсан тохиолдолтой хавьтал болсон өдрөөс эхлэн нууц үеийн 14 хоногийн хугацаанд цуглуулсан сорьц;

- 3.3. Батлагдсан тохиолдлын хавьталд шинж тэмдэг илэрсэн тохиолдлын сорьц;
- 3.4. КОВИД-19 антиген илрүүлэх шинжилгээгээр эерэг гарсан тохиолдлын сорьц;
- 3.5. Батлагдсан тохиолдлын эмчилгээний хяналтын сорьцуудыг
- 3.6. Цэр, гуурсан хоолойн шингэн зэрэг амьсгалын доод хэсгийн сорьц, баас, шээс, эдийн сорьцыг шинжилэхдээ.

**БХ-УТ-ПГУ -ын шинжилгээнд сорьцыг багцалж ХИЙХ тохиолдол**

КОВИД-19 халдварын голомт гарсан хот, аймаг, дүүргийн хүн амын дунд уг халдварын өргөжүүлсэн тандалт хийж буй тохиолдолд сорьцыг багцлах аргаар шинжилж болно.

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны / сарын 10 / едрийн 11 тушаалын  
туравдугаар хавсралт 806

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД  
ЭСРЭГ БИЕ ИЛРҮҮЛЭХ ХУРДАВЧИЛСАН ОНОШЛУУРААР  
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТҮР ЗААВАР

**НЭГ. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**

1.1. Эсрэг бие илрүүлэх хурдавчилсан оношлуур нь хүний бүхэл цус, ийлдэс, сийвэнд SARS-CoV-2 вирусын эсрэг үүссэн IgM, IgG эсрэг биеийг чанарын аргаар илрүүлэх иммунохроматографийн арга юм.

1.2. IgM эсрэг бие нь шинж тэмдэг илэрснээс хойш 1 долоо хоногийн дараа үүсэж тухайн хүний дархлааны байдлаас хамааран ийлдсэнд 8 долоо хоног хүртэл илэрнэ. Халдвартын эрт үед IgM эсрэг бие эерэг түүнчлэн БХ-УТ-ПГУ зэрэг гардаг бол халдвартын хожуу үед IgM эсрэг бие эерэг, БХ-УТ-ПГУ сөрөг гарна.

1.3. IgG эсрэг бие нь шинж тэмдэг илэрснээс хойш 1 долоо хоногийн дараа үүсч тухайн хүний дархлааны байдлаас хамааран ийлдсэнд 6 сар хүртэл буюу түүнээс урт хугацаанд илэрч болно. IgG зэрэг гарахад эдгэрсэн гэж шууд хэлэх боломжгүй.

1.4. Шинжилгээний үр дүн нь өвчин эхэлсэн хугацаа эмнэлзүйн шинж тэмдэг, тухайн хүн ам дахь тархалт, хэрэглэсэн шинжилгээний төрөл, баталгаажуулсан арга, шинжилгээний үнэн магадтай байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

**ХОЁР. ХЭРЭГЛЭХ ТОХИОЛДОЛ**

2.1. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын үед эсрэг бие илрүүлэх хурдавчилсан оношлуурыг цар тахлын үеийн халдвартын тархац, цар хүрээг тогтоох эргэмж судалгаанд (шинж тэмдэггүй халдвартыг илрүүлэх) ашиглана.

2.2. Тархвар судлалын хүчтэй хамааралтай, бодит хугацааны ПГУ-ын шинжилгээ сөрөг тохиолдолд серологийн шинжилгээг давтан авах нь (Нэгдүгээр нь өвчний хурц үед буюу эхний долоо хоногт, хоёрдугаар нь 2-4 долоо хоногийн дараа) оношилгооны ач холбогдолтой.

2.3. Бусад вируст халдвартай солбицон мэдрэх урвалын улмаас хуурамч зэрэг хариу гарах эрсдэлтэй.

2.4. Дархлаажуулалтын дархлал тогтцыг үнэлэхэд эсрэгбие илрүүлэх шинжилгээг хийж болно.

**ГУРАВ. ХЭРЭГЛЭХГҮЙ ТОХИОЛДОЛ**

3.1. Батлагдсан тохиолдлын хавьтлыг мөшгихэд хэрэглэхгүй.

3.2. Шинжилгээний үр дүнг оношилгоо, эмчилгээний шийдвэр гарахад дангаар ашиглахгүй бөгөөд эмнэлзүй, бусад шинжилгээний хариутай харьцуулан тайлбар хийнэ.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ЭСРЭГ БИЕ ИЛРҮҮЛЭХ  
ФЕРМЕНТ ХОЛБООТ УРВАЛ (ФХУ), ЭЛЕКТРОХЕМОЛЮМИНЕСЦЕНЦИЙН  
ШИНЖИЛГЭЭ (ХЛИА) ХИЙХ ТҮР ЗААВАР

**НЭГ. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**

1.1. Эсрэг бие илрүүлэх фермент холбоот эсрэг биеийн шинжилгээ, электрохемолюминесценцийн шинжилгээ (ХЛИА) шинжилгээ нь хүний цусны ийлдэс, сийвэнд SARS-CoV-2 вирусын эсрэг үүссэн IgM, IgG эсрэгбиийг чанарын аргаар илрүүлэх шинжилгээний арга юм.

1.2. IgM эсрэг бие нь шинж тэмдэг илэрснээс хойш 1 долоо хоногийн дараа үүсэж тухайн хүний дархлааны байдлаас хамааран ийлдсэнд 8 долоо хоног хүртэл илэрнэ. Халдвартын эрт үед IgM эсрэг бие эерэг түүнчлэн БХ-УТ-ПГУ эерэг гардаг бол халдвартын хожуу үед IgM эсрэг бие эерэг, БХ-УТ-ПГУ сөрөг гарна. IgM эерэг гарах нь дараах тохиолдол байж болно (Халдвартын хожуу үед, солбицон мэдрэх урвалын улмаас хуурамч эерэг хариу гарах)

1.3. IgG эсрэг бие нь шинж тэмдэг илэрснээс хойш дунджаар 2-3 долоо хоногийн дараа үүсч тухайн хүний дархлааны байдлаас хамааран ийлдсэнд 6 сар хүртэл буюу түүнээс урт хугацаанд илэрч болно. IgG эерэг гарахад эдгэрсэн гэж шууд хэлэх боломжгүй бөгөөд коронавируст халдвартын (КОВИД-19)-ын үед ийлдсийн IgG-ийн агууламжаар дархлаа тогтсон эсэхийг тогтоохгүй. IgG эерэг гарах нь дараах гурван тохиолдол байж болно (1. Шинэ халдвартын одоо тухайн хүний биед өрнөж байх үед 2. Халдвартын эдгэрсэн, вирус биеэс зайлцуулагдсан үед 3. Коронавирусын өөр төрлийн халдвартын бусад вируст халдвартай солбицон мэдрэх урвалын улмаас хуурамч эерэг хариу гарах үед)

1.4. Шинжилгээний үр дүн нь өвчин эхэлсэн хугацаа эмнэлзүйн шинж тэмдэг, тухайн хүн ам дахь тархалт, хэрэглэсэн шинжилгээний төрөл, баталгаажуулсан арга, шинжилгээний үнэн магадтай байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Эсрэг бие илрүүлэх шинжилгээний хариу сөрөг гарах нь SARS-CoV-2 вирусын цочмог халдвартыг үгүйсгэхгүй.

**ХОЁР. ХЭРЭГЛЭХ ТОХИОЛДОЛ**

2.1. Коронавируст халдвартын (КОВИД-19)-ын үед эсрэг бие илрүүлэх фермент холбоот эсрэг бие илрүүлэх шинжилгээ, электрохемолюминесценцийн шинжилгээ (ХЛИА)-г цар тахлын үеийн халдвартын тархац, цар хүрээг тогтоох эргэмж судалгаанд (шинж тэмдэггүй халдвартыг илрүүлэх) ашиглана.

2.2. Тархвар судлалын хүчтэй хамааралтай, бодит хугацааны ПГУ-ын шинжилгээ сөрөг тохиолдолд серологийн шинжилгээг давтан авах нь (1. Өвчиний хурц үед буюу эхний долоо хоногт 2. 2-4 долоо хоногийн дараа) оношилгооны ач холбогдолтой.

2.3. Бусад вируст халдвартай солбицон мэдрэх урвалын улмаас хуурамч эерэг хариу гарах эрсдэлтэй. Коронавируст халдвартын (КОВИД-19)-ын нэн эрт үед фермент холбоот эсрэг бие илрүүлэх шинжилгээ, электрохемолюминесценцийн шинжилгээ (ХЛИА)-ний хариу сөрөг гарч болно. Коронавируст халдвартын (КОВИД-19)-

ын үед эсрэг бие илрүүлэх шинжилгээгээр шинжилүүлэгчийг халдвартай, бусдад халдвар тараах эрсдэлтэй гэж оношлох боломжгүй.

2.4. Ажлын байран дээр хувийн хамгаалах хэрэгсэл өмсөж, хэрэглэж байгаа хүмүүст анти-SARS-CoV-2 эсрэг бие цусанд нь илэрсэн ч хувийн хамгаалах хэрэгслийг үргэлжлүүлэн хэрэглэнэ.

2.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хожуу үеийн хүндрэлийн үед оношийг баталгаажуулах зорилгоор эсрэг бие илрүүлэх шинжилгээг хийхийг зөвлөдөг. Ялангуяа хүүхдэд олон эрхтэн тогтолцоог хамарсан үрэвслийн хамшинж (multisystem inflammatory syndrome) илэрсэн тохиолдолд оношийг баталгаажуулахад чухал чухал ач холбогдолтой.

2.6. Дархлаажуулалтын дархлал тогтоцыг үнэлэхэд эсрэг бие илрүүлэх шинжилгээг хийж болно.

## ГУРАВ. ХЭРЭГЛЭХГҮЙ ТОХИОЛДОЛ

3.1. Батлагдсан тохиолдлын хавьтлыг мөшгихөд хэрэглэхгүй.

3.2. Эсрэг бие илрүүлэх шинжилгээ нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын идэвхтэй халдварыг илрүүлэхгүй.

3.3. Шинжилгээний үр дүнг оношилгоо, эмчилгээний шийдвэр гаргахад дангаар ашиглахгүй бөгөөд эмнэлзүй, бусад шинжилгээний хариутай харьцуулан тайлбар хийнэ.

3.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед ийлдсийн IgA-ийн хөдлөл зүйн талаар тодорхой мэдээлэл хомс тул IgA эсрэг бие илрүүлэх шинжилгээг зөвлөхгүй.

--oo0oo--